

АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАМГААЛАЛТЫН АЛБАНЫ
ҮЗЛЭГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ техникийн тодорхойлолтод Аюулгүй байдал хамгаалалтын албанд ашиглагдах зорчигчийн тээш болон гар тээш шалгалтын рентген цацрагийн төхөөрөмж, зорчигчийн биед шалгалт хийх металл илрүүлэгч төхөөрөмжүүдийн техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн төхөөрөмжүүдийг нийлүүлнэ.

- 2.1 Системийн командын интерфейс нь англи хэлээр байна.
- 2.2 Үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээний хуулбар ирүүлэх.
- 2.3 Техникийн бичиг баримт, програм хангамжийн болон дэлгэцийн интерфейс нь англи хэлээр байна.
- 2.4 Эцсийн цэгт суурилуулалт хийх.

3 ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүд нь доорх шаардлагыг бүрэн хангасан байна.

3.1 Аюулгүй байдлын үзлэгт ашигладаг зорчигчийн тээш болон гар тээш шалгалтын рентген цацрагийн төхөөрөмжийн техникийн шаардлага

№	Үзүүлэлт	Шаардлагатай техникийн үзүүлэлт
1.	Шалгалтын хонгилын хэмжээ	755(W) x 555(H) мм – с ихгүй байх
2.	Конвейрын өндөр	790 мм-с ихгүй байх
3.	Конвейрын хурд	0.20 м/с байх
4.	Конвейрын даац	Нийт уртын хэмжээндээ 160кг ба түүнээс дээш жинтэй ачаа даадаг байх
5.	Нягтаршил буюу төмөр утасны илрүүлэлт	38AWG(0.1мм) – с багагүй байх
6.	Төмөр нэвтрэх чадвар	27мм ба түүнээс дээш байх
7.	Рентген туяаны дозе	1.8 μ Sv/h (0.18mrem/h) – с ихгүй байх
8.	Гэрэл зургийн хальсны аюулгүйн түвшин	1600ASA буюу 33 DIN хүртэл хурдтай хальсанд нөлөөлөхгүй байх
9.	Рентген генераторын анодын хүчдэл	160kV- с ихгүй байх
10.	Рентген генераторын тусах өнцөг	Доороос дээш диагналаар тусдаг байх
11.	Рентген туяаны хувиргалт	L хэлбэрийн детекторын шугаман хувиргалттай байх
12.	Рентген туяаны алдагдал	Төхөөрөмжөөс 5см-ын зайд 2 μ Sv/h (0.2mR/h) –с ихгүй байх

		desk/ мөн оролтын 500-600мм, гаралтын 2000мм-с ихгүй урттай нэмэлт роликтой байх
25.	Техник ашиглалтын заавар	Төхөөрөмж нь өөрийн техник ашиглалтын заавартай байхаас гадна англи болон монгол хэл дээр операторын ашиглалтын заавар тус бүр нэг нэг хувь байх шаардлагатай
26.	Баталгаат хугацаа	Төхөөрөмжийг ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар байх
27.	Брэндийн хувьд	Төхөөрөмж нь HEIMANN HI-SCAN 7555i эсвэл Rapiscan 622XR-тэй дүйцэхүйц байх.

3.1 Аюулгүй байдлын үзлэгт ашигладаг зорчигчийн биед шалгалт хийх металл илрүүлэгч төхөөрөмж /хаалга/-ийн техникийн шаардлага

№	Техникийн үзүүлэлт	Техникийн үзүүлэлтэнд тавигдах шаардлага
1.	Илрүүлэх металлын төрөл	Соронзот болон соронзот биш металлуудыг бүгдийг илрүүлдэг байх
2.	Мэдрэмжийн түвшин	100 хүртэл түвшинтэй байх
3.	Дохиолол болон нэмэлт функц	Дуут болон гэрлэн дохиололтой /хүний биед байгаа металлын түвшингээр гэрэлтдэг LED / байх мөн Random Alarm Function буюу санамсаргүй дохиололын функц, орсон хүний болон дохиолол өгсөн хүний тоо гардаг тоолууртай байх
4.	Ажиллах цахилгаан тэжээл	Нэг фазын, 230V $\pm 15\%$ хувьсах гүйдлийн(AC), 50Гц-ийн давтамжтай байх шаардлагатай
5.	Ажиллах температур	-20°C - +60°C –ийн хооронд ажилладаг байх
6.	Харьцангуй чийг	0 - 95%
7.	Холбогдох интерфейс	RS232 болон Ethernet сүлжээнд холбогдох боломжтой байх
8.	Ажиллах программ	Ажиллах программ хангамжийн хувьд ашиглалт болон тохиргоо, үйлчилгээ хийхэд хялбар байх
9.	Стандарт	ISO 9001 бүлгийн стандартууд, CE ба FCC стандартуудыг хангасан мөн магнитен өгөгдөл хадгалах материалуудад, зүрхний аппараттай хүн, жирэмсэн эмэгтэйчүүдэд ямар нэг хор нөлөөгүй байх
10.	Овор хэмжээ	дотор талдаа: 2050мм х 720-820мм-с ихгүй гадна талдаа: 2255мм х 935мм х 700мм-с ихгүй
11.	Техник ашиглалтын заавар	Төхөөрөмж нь өөрийн техник ашиглалтын заавартай байх ба англи болон монгол хэл дээр тус бүр нэг нэг хувь байх шаардлагатай

12.	Баталгаат хугацаа	Төхөөрөмжийг ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар байх
13.	Брэндийн хувьд	Төхөөрөмж нь CIEA HI-PE Multizone эсвэл Rapiscan Metor 6M-тэй дүйцэхүйц байх.

4 ХҮЛЭЭН АВАХ

- 4.1. Нийлүүлэгч тал нь техникийн үзүүлэлтийг бүрэн хангасан тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн шалгалт тохируулга хийсэн баримт, хэмжилт тохируулгын гэрчилгээний хамт нийлүүлнэ.
- 4.2. Нийлүүлэгч тал нь тоног төхөөрөмжийг суурилуулж, ашиглалтын горимд 5 хоногийн хугацаанд ажиллуулсны дараа төхөөрөмжийг хүлээлгэн өгнө.
- 4.3. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу техникийн үзүүлэлт болон иж бүрдлийг шалгаж, ажил хүлээн авах актыг үйлдсэнээр барааг хүлээн авсанд тооцно.
- 4.4. Баталгаат засварын хугацаа нь ажил хүлээн авах комисс гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар байна.
- 4.5. Сургалтыг инженер техникийн ажилчид, үзлэгийн аюулгүй байдлын ажилтнуудад явуулна.
- 4.6. Ачааг хүргэх цэг: Баян-Өлгий аймгийн Өлгий, Хөвсгөл аймгийн Мөрөн, Завхан аймгийн Доной, Баянхонгор аймгийн Баянхонгор, Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлуудад хүргэнэ.